

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 14-ний өдөр

То №1

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11 дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6.2.6.5 заалт, компанийн 2020 оны 2 сарын 14-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хавсралтаар баталсугай.
2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хэлэлцүүлсүгэй.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л. АРИУНБОЛД

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 14-ний өдөр

То №2

Улаанбаатар хот

Компанийн бизнес төлөвлөгөөг батлах тухай

“Монгол Базальт” ХК-ийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2020 оны бизнес төлөвлөгөөг хавсралт 1-ээр баталсугай.
2. Компанийн бизнес төлөвлөгөө хэрэгжүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар мэдээллээр хангаж ажиллахыг гүйцэтгэх захиралд, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд тус тус үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л. АРИУНБОЛД

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 14-ний өдөр

То №3

Улаанбаатар хот

“Монгол Базальт” ХК ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6, 46.8 заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 заалт, “Монгол Базальт” ХК –ийн 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны цэвэр ашгийн 68 %-ийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тараахаар шийдвэрлэж, нэгж хувьцаанд 4 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.
3. “Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг ҮЦТХТ дэх дансанд 2020 оны 6 дугаар сарын 30-ний өдрөөс өмнө ҮЦТХТ-тэй гэрээ байгуулан ногдол ашгийг байршуулахыг Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД

МОНГОЛ БАЗАЛЫТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 14-ний өдөр

То №4

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 76.1.2, 76.1.3 дах заалт, 60 дугаар зүйл 60.1, 60.2-д заалтууд, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийг 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монгол базальт” ХК-ийн дүрмийн 6.2.6.3, 6.2.6.4 заалтууд, 2020 оны 2 сарын 14-ний өдрийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, ерөнхий сайд Амарын гудамж, Туушин зочид буудлын хурлын танхимд зарлан хуралдуулахаар тогтсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 1. “Монгол Базальт” ХК-ийн жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох,
 3. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалын хэмжээг тогтоох
 4. ОХУ-ын Ангарск мужид салбар үйлдвэр байгуулах тухай хэлэлцэж батлах,
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 3 дугаар сарын 9-ны өдрөөр тогтоосугай.
4. “Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, компанийн өөрийн цахим хуудас, өдөр тутмын нэг сонинд, радио болон телевизийн аль нэгээр мэдээлсүгэй.

5. Хурлын давтан зарыг 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу өдөр тутмын сонин болон радио телевизийн аль нэгнээр мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигч нь энэхүү шийдвэрийн 1 дүгээр хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 11⁰⁰-16⁰⁰ цагийн хооронд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, “Фламинго Тауэр” 7 давхарт ирж танилцаж болох, мөн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хандан авах боломжтойг дурьдсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар материал, 1 дүгээр хавсралтанд заасан баримт бичгийн бэлэн болгох эцсийн хугацааг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөр тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал, хурлаас гаргах тогтоол шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох хурлын материалыг олон нийтэд зар хүргэснээс хойш 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй үнэт цаасны компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргэсүгэй.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2 дугаар хавсралтаар баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 3 дугаар хавсралтаар баталсугай.
11. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцох боломжгүй, урьдчилан саналын хуудсаар санал өгөх тохиолдолд саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 16 цаг байхаар тогтсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар А.Энхгэрэл, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр Б.Амарбаясгалан, Цэрэнпагма, Амаржаргал, Уранбилэг тус тус томилсугай.
14. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Уранбилэг, тооллогын комиссын гишүүнээр Саруулсайхан, Сайнбаатар, Байгальмаа -ийг тус тус томилсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л. АРИУНБОЛД